

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70357955 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.24 № 67

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
Ж.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/411 дүгээр тушаал, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2022 оны А/44 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төслийн багц-2-ын үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих бүрдэл тоног төхөөрөмж, бизнес эрхлэгчдийг дэмжих "Смарт эзэд" хөтөлбөр багц-1 тавилга, эд хогшил, бизнес эрхлэгчдийг дэмжих "Смарт эзэд" хөтөлбөр багц-2-ын компьютер, тоног төхөөрөмж нийт 1,150,057,0 мянган төгрөгийн хөрөнгийг иргэдэд олгохоор тусгай зориулалтын дансанд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлангийн хугацаанд Орхон аймгийн Засаг даргын захирамжаар 198,334.4 мянган төгрөгийн 21 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/411 дүгээр тушаал, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2022 оны А/44 дүгээр тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бизнес эрхлэгчдийг дэмжих "Смарт эзэд" хөтөлбөр багц-1 тавилга, эд хогшил, бизнес эрхлэгчдийг дэмжих "Смарт эзэд" хөтөлбөр багц-2-ын компьютер, тоног төхөөрөмж нийт 239,635.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудиторт аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>148,504,743.90</u>	<u>1,429,698,232.96</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,754,300.00	894,300.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,754,300.00	894,300.00
3121	Төгрөг	1,754,300.00	894,300.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,754,300.00	894,300.00
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	139,550,443.90	1,428,803,932.96
351	Түүхий эд материал	33,598,979.88	1,186,613,103.54
35110	Тусгай зориулалттай материал	33,598,979.88	1,186,613,103.54
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	99,198,695.40
354	Хангамжийн материал	105,951,464.02	142,992,134.02
35410	Бичиг хэргийн материал	166,720.00	342,650.00
35420	Аж ахуйн материал	2,309,060.00	3,773,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,550,000.00	2,550,000.00
35440	Түлш, шатах тослох материал	420,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	100,505,684.02	136,325,684.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>82,812,761.00</u>	<u>330,172,315.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	82,812,761.00	330,172,315.67
392	Биет хөрөнгө	76,025,761.16	324,385,315.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	61,364,496.87	61,364,496.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,255,741.48)	(16,980,536.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112,748,772.52	112,748,772.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	(102,073,772.22)	(109,637,661.23)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,225,197.23	206,410,097.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,198,086.73)	(34,536,389.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,596,963.16	121,100,963.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,382,068.19)	(16,084,426.93)
393	Биет бус хөрөнгө	6,786,999.84	5,786,999.92
39301	Програм хангамж	4,300,000.00	4,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,375,000.16)	(3,375,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,862,000.00	4,862,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>231,317,504.90</u>	<u>1,759,870,548.63</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>231,317,504.90</u>	<u>1,759,870,548.63</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>231,317,504.90</u>	<u>1,759,870,548.63</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	292,689,889.75	292,689,889.75
51101	Өмч: - төрийн	292,689,889.75	292,689,889.75
512	Хуримтлагдсан үр дүн	(66,696,775.95)	1,461,856,267.78
51210	Өмнөх үеийн үр дүн	(87,456,522.33)	(66,696,775.95)
51220	Тайлант үеийн үр дүн	20,759,746.38	1,528,553,043.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,324,391.10	5,324,391.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>231,317,504.90</u>	<u>1,759,870,548.63</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	611,170,069.07	2,476,195,289.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	192,219,369.07	1,674,837,581.50
120	Нийтлэг татварын бус орлого	192,219,369.07	1,674,837,581.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	192,219,369.07	1,674,837,581.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	366,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	191,853,369.07	1,674,837,581.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		265,429,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		1,409,408,181.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,950,700.00	801,357,708.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,678,000.00	299,523,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	317,678,000.00	299,523,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,272,700.00	501,834,408.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,272,700.00	498,334,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	8.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	433,984,553.64	916,251,277.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,984,553.64	916,251,277.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,900,376.68	884,889,883.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,177,456.88	217,171,579.47
210101	Үндсэн цалин	152,012,214.47	162,160,330.45
210102	Нэмэгдэл	40,459,241.13	33,396,838.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,706,001.28	13,020,400.00
210104	Урамшуулал	-	8,594,010.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,284,884.23	27,154,794.47
210201	Тэтгэврийн даатгал	18,416,156.94	18,610,850.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,051,068.57	2,189,511.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,640,855.01	1,744,889.42
210204	Ажилгүйдлийн даатгал	379,709.57	419,049.22
210205	Эрүүл мэндийн даатгал	3,797,094.14	4,190,493.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,978,655.93	28,526,519.98
210301	Гэрэл, цахилгаан	882,434.72	579,076.31
210302	Түлш, халаалт	1,827,310.08	1,991,726.55
210303	Цэвэр, бохир ус	2,491,695.13	1,128,501.12
210304	Байрны түрээс	13,777,216.00	24,827,216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,180,507.00	123,758,777.44
210401	Бичиг хэрэг	20,356,095.00	5,082,270.00
210402	Тээвэр, шатахуун	21,668,200.00	32,385,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,186,736.00	1,126,347.44
210404	Ном, хэвлэл	-	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	595,000.00	246,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,374,476.00	84,898,860.00
2105	Нормативт зардал	44,518,000.00	21,348,301.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,992,000.00	745,000.00
210502	Хоол, хүнс	-	20,603,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,526,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,570,000.00	1,960,000.00
210604	Урсгал засвар	2,570,000.00	1,960,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,334,200.00	8,795,800.00
210702	Дотоод албан томилолт	2,334,200.00	8,795,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,309,590.00	331,982,614.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,316,500.00	324,675,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,960.00	201,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,470.00	417,470.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	5,940,000.00
210807	Газрын төлбөр	39,660.00	131,184.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,547,082.64	124,191,497.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,238,520.00	102,862,152.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,308,562.64	21,329,345.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,084,176.96	31,361,395.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,119,600.00	13,360,001.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,283,900.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,835,700.00	13,360,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,964,576.96	18,001,394.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,964,576.96	10,153,644.64
21305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		7,847,750.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	177,185,515.43	1,559,944,011.73
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	156,425,769.05	31,390,968.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	156,425,769.05	31,390,968.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(156,425,769.05)	(31,390,968.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	20,759,746.38	1,528,553,043.73

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	419,852,633.00	809,205,450.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	366,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	366,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	366,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	366,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	419,486,633.00	809,205,450.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,678,000.00	299,523,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	317,678,000.00	299,523,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,272,700.00	509,682,150.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,272,700.00	498,334,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,847,750.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	535,933.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	535,933.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	420,504,033.00	810,065,450.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,504,033.00	810,065,450.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,757,923.04	778,704,055.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,177,456.88	217,171,579.47
210101	Үндсэн цалин	151,972,183.74	162,160,330.45
210102	Нэмэгдэл	40,499,271.86	33,396,838.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,706,001.28	13,020,400.00
210104	Урамшуулал	-	8,594,010.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,284,884.23	27,154,794.47
210201	Тэтгэврийн даатгал	18,416,156.94	18,610,850.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,051,068.57	2,189,511.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,640,855.01	1,744,889.42
210204	Ажилгүйдлийн даатгал	379,709.57	419,049.22
210205	Эрүүл мэндийн даатгал	3,797,094.14	4,190,493.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,258,655.93	28,676,519.98
210301	Гэрэл, цахилгаан	1,162,434.72	729,076.31
210302	Түлш, халаалт	1,827,310.08	1,991,726.55
210303	Цэвэр, бохир ус	2,491,695.13	1,128,501.12
210304	Байрны түрээс	13,777,216.00	24,827,216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,909,286.00	90,431,647.44
210401	Бичиг хэрэг	19,496,650.00	3,988,200.00
210402	Тээвэр, шатахуун	17,748,200.00	29,912,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,186,736.00	1,126,347.44
210404	Ном, хэвлэл	-	12,508,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	595,000.00	37,371,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,882,700.00	5,526,000.00
2105	Нормативт зардал	46,023,000.00	23,613,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,296,000.00	745,000.00
210502	Хоол, хүнс	-	18,258,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,727,000.00	4,610,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,051,000.00	9,372,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	772,000.00	3,952,500.00
210604	Урсгал засвар	7,279,000.00	5,420,300.00
2107	Томилот, зочны зардал	2,334,200.00	8,795,800.00
210702	Дотоод албан томилот	2,334,200.00	8,795,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,839,590.00	345,133,614.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,646,500.00	343,226,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,960.00	201,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,470.00	417,470.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	39,660.00	131,184.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	879,850.00	28,353,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	879,850.00	28,353,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,746,109.96	31,361,394.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,781,533.00	13,360,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	535,933.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,283,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,961,700.00	13,360,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,964,576.96	18,001,394.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,964,576.96	18,001,394.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(651,400.00)	(860,000.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	564,300.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	564,300.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	564,300.00	-
222001	Тоног төхөөрөмж	564,300.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(564,300.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,215,700.00)	(860,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,970,000.00	1,754,300.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,754,300.00	894,300.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	550,935,889.75	5,324,391.10	-87,456,522.33	0.00	468,803,758.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,935,889.75	5,324,391.10	-87,456,522.33	0.00	468,803,758.52
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-258,246,000.00	0.00	0.00	0.00	-258,246,000.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	20,759,746.38	0.00	20,759,746.38
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	-66,696,775.95	0.00	231,317,504.90
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	-66,696,775.95	0.00	231,317,504.90

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	-66,696,775.95	0.00	231,317,504.90
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,528,553,043.73	0.00	1,528,553,043.73
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	1,461,856,267.78	0.00	1,759,870,548.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	299,523,300.00	289,369,655.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,523,300.00	289,369,655.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,015,500.00	288,869,655.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,414,600.00	217,171,579.47
210101	Үндсэн цалин	164,573,600.00	162,160,330.45
210102	Нэмэгдэл	34,615,700.00	33,396,838.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,079,000.00	13,020,400.00
210104	Урамшуулал	9,146,300.00	8,594,010.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,676,700.00	27,154,794.47
210201	Тэтгэврийн даатгал	18,820,200.00	18,610,850.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,214,100.00	2,189,511.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,771,300.00	1,744,889.42
210204	Ажилгүйдлийн даатгал	442,800.00	419,049.22
210205	Эрүүл мэндийн даатгал	4,428,300.00	4,190,493.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,099,100.00	17,076,519.98
210301	Гэрэл, цахилгаан	608,700.00	579,076.31
210302	Түлш, халаалт	2,006,400.00	1,991,726.55
210303	Цэвэр, бохир ус	1,106,800.00	1,128,501.12
210304	Байрны түрээс	13,377,200.00	13,377,216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,474,300.00	5,623,847.44
210401	Бичиг хэрэг	2,379,300.00	2,186,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,836,700.00	1,390,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,074,700.00	1,056,347.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,000.00	246,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	937,600.00	745,000.00
2105	Нормативт зардал	2,015,900.00	1,870,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,015,900.00	1,870,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,159,500.00	9,372,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,239,600.00	3,952,500.00
210604	Урсгал засвар	5,919,900.00	5,420,300.00
2107	Томилот, зочны зардал	7,591,300.00	5,293,800.00
210702	Дотоод албан томилот	7,591,300.00	5,293,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,784,100.00	4,507,614.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,600,000.00	2,600,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	726,100.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	270,900.00	201,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	417,500.00	417,470.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	129,500.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	1,100,100.00	131,184.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	798,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	798,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	507,800.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	507,800.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	507,800.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	299,523,300.00	289,369,655.36
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	299,523,300.00	289,369,655.36
122005	Орон нутгийн төсвөөс	299,523,300.00	289,369,655.36
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	19.00	18.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	18.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	501,834,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,834,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,834,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,600,000.00
210301	Гэрэл, цахилгаан	150,000.00
210304	Байрны түрээс	11,450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	84,807,800.00
210401	Бичиг хэрэг	1,801,700.00
210402	Тээвэр, шатахуун	28,522,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00
210404	Ном, хэвлэл	12,508,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,125,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,781,000.00
2105	Нормативт зардал	21,743,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	745,000.00
210502	Хоол, хүнс	18,258,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,740,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,502,000.00
210702	Дотоод албан томилолт	3,502,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	340,626,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	340,626,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,555,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,555,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,847,750.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,000,000.00

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,847,750.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	7,847,750.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	501,834,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	501,834,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	498,334,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,853.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 17,853.3 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Үүнд: Бараа материалын тайланд бусад хангамжийн материалд 17 853.3 мянган төгрөгийн хүнсний материал тайлагнасан Зардал хооронд болон бараа материал ангилал хооронд нь гүйлгэн тайлагнасан.

Аудитаар нийт 21,134.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 273.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 19,979.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 881.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийг гэр хорооллын ажилчдын тодорхойлолт судалгааг үндэслээгүй бүх ажилчдад олгож нийт 273.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 6-р тогтоол "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам" -ын 8.2-д "албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврээр зорчих шаардлагатай бол нийтийн тээврийн унааны 50 хувийг байгууллагаас олгоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Албан шаардлага

1. Аймгийн ЗД-ын захирамжаар хийгдэж буй төсөл хөтөлбөр ба нэмэлт санхүүжилтийн 19,979.7 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтанд хяналт тавигддаггүй, жишиг нормыг өндрөөр тооцдог, явсан км-ыг тодорхой явсан газар /ажил/ тус бүрээр бичиж тооцоо боддоггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дүгээр тушаалын "автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансанд 7 сарын 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3.-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Томилолтын зардалд 732.0 мянган төгрөгийн унааны баримт хувь хүний сугалаатай баримтаар гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан "дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасан зөрчигдсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахгүй байх. Дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулж, хяналт тавьж ажиллах.

3. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилтны амралтыг бодохдоо групп тогтоолгосон хүнд нэмж олгох 5 хоногийн амралтын мөнгийг, ажилласнаар тооцон 149.5 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүнд өгч байгаа ажил үйлчилгээний хөлсийг олгохдоо холбогдох хуулиудын дагуу шимтгэл, татварыг тооцож олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын тайланд бусад хангамжийн материалд 17,853.3 мянган төгрөгийн хүнсний материал тайлагнасан Зардал хооронд болон бараа материал ангилал хооронд нь гүйлгэн тайлагнасан.	1	17,853.3			1	17,853.3	1	17,853.3				
Дүн	1	17,853.3			1	17,853.3	1	17,853.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууныг хяналтгүй зарцуулсан. Жишиг нормыг өндрөөр тооцдог, явсан км-ыг тодорхой явсан газар /ажил/ тус бүрээр бичиж тооцоо боддоггүй байна.	1	19,979.7			1	19,979.7						
Нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийг гэр хорооллын ажилчдын тодорхойлолт судалгааг үндэслээгүй бүх ажилчдад олгосон байна.	1	273.6			1	273.6						
Групптэй ажилтны амралтыг бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж тооцоогүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон байна.	1	149.5					1	149.5				

Томилолтын зардалд унааны баримт, хувь хүний сугалаатай баримтаар гүйлгээ хийгдсэн байна.	1	732.0					1	732.0			
Дүн	4	21,134.2			2	20,253.3	2	881.5			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөг/ Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансанд 7 сарын 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-					1	-
Нийт дүн	1	-					1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			